



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 410

Улаанбаатар хот

Сургагч багш нарын нэрс,  
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний стратегийг хэрэгжүүлэх сургалтыг орон нутагт зохион байгуулах сургагч багш нарын нэрс, ажиллах аймгийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний стратегийг хэрэгжүүлэх сургалтын бэлтгэл ажлыг ханган, холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулахыг аймгуудын Эрүүл мэндийн газрын дарга нарт, сургагч багш нарын ажлыг зохицуулан хуваарилагдсан аймагт явуулахыг харьяалах байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Сургалтын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг хангаж, 2015 оны 10-11 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д даалгасугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081350

Эрүүл мэнд, спортын сайдын 2015  
оны 10-р сарын 14-ны өдрийн 410-р  
тушаалын хавсралт



“Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж”  
сургалтыг орон нутагт явуулах сургагч багш нарын нэрс, хуваарь

№	Аймаг	Сургагч багш		Хугацаа
1.	Архангай	Х.Цэцэгдэлгэр, Амгалан амаржих	С.Энхтуяа, ЭХЭМҮТ	10 сар
2.	Баянхонгор	Б.Баясгалантай, АШУУИС	Б.Амгалан, АШУУИС	10 сар
3.	Баян-Өлгий	Б.Жаргалсайхан, АШУУИС	Б.Баясгалантай, ЭХЭМҮТ	10 сар
4.	Булган	П.Цэцэгмаа, АШУУИС	С.Энхтуяа, ЭХЭМҮТ	10 сар
5.	Говь-Алтай	Б.Баттулга, ЭХЭМҮТ	С.Гантуяа, ЭМСЯ	10 сар
6.	Говь-Сүмбэр	Н.Болормаа, ЭМСЯ	Б.Дэлгэрсайхан, Хүрээ амаржих	10 сар
7.	Дархан-Уул	Б.Баттулга, ЭХЭМҮТ	Д.Тунгалаг, ЭХЭМҮТ	10 сар
8.	Дорнод БОЭТ	Б.Жаргалсайхан, АШУУИС	С.Гантуяа, ЭМСЯ	11 сар
9.	Дорноговь	Н.Болормаа, ЭМСЯ	Б.Дэлгэрсайхан, Хүрээ амаржих	10 сар
10.	Дундговь	Н.Болормаа, ЭМСЯ	Ж.Эрдэнэчимэг, Өргөө амаржих	10 сар
11.	Завхан	А.Алтанцэцэг, ЭХЭМҮТ	Д.Гэрэлтуяа, ЭХЭМҮТ	10 сар
12.	Орхон	Ж.Энхтуяа, ЭХЭМҮТ	Б.Түвшиндэлгэр, Амгалан амаржих	10 сар
13.	Өвөрхангай	Б.Баясгалантай, АШУУИС	С.Гантуяа, ЭМСЯ	10 сар
14.	Өмнөговь	Н.Болормаа, ЭМСЯ	Ж.Эрдэнэчимэг, Өргөө амаржих	10 сар
15.	Увс	Г.Батсайхан, ЭХЭМҮТ	Д.Тунгалаг, ЭХЭМҮТ	10 сар
16.	Сүхбаатар	Д.Гэрэлмаа, Интермед	С.Гантуяа, ЭМСЯ	10 сар
17.	Сэлэнгэ	Л.Цэвэлмаа, Хүрээ амаржих	Б.Баясгалантай, АШУУИС	10 сар
18.	Ховд	Ж.Энхтуяа, ЭХЭМҮТ	Б.Түвшиндэлгэр, Амгалан амаржих	10 сар
19.	Хэнтий	Д.Гэрэлмаа, Интермед	С.Гантуяа, ЭМСЯ	10 сар
20.	Төв	Х.Цэцэгсүрэн, АШУУИС	Д.Оюунцэцэг, Хүрээ амаржих	10 сар